



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 24 өдөр

Дугаар A/269

Булган сум

┌ Байгууллагын төсвөөс хөрөнгө гаргах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор Хойд бүсийн зөвлөгөөн, Засгийн газрын өргөтгөсөн хурал 2025 оны 04 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд Булган аймагт зохион байгуулахтай холбогдуулан түүнд оролцох Засгийн газрын гишүүд, харьяа яамны холбогдох байгууллагуудын төлөөллийг хүлээн авч үйлчлэх, Булган аймагт ажиллах үеийн арга хэмжээг салбарын хэмжээнд зохион байгуулахыг Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсвийг өөрийн байгууллагын төсвөөс гаргахыг байгууллагын дарга, эрхлэгч, нягтлан бодогч нар зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

